



**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**  
FINANCIAL REGULATORY COMMISSION  
OF MONGOLIA

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2019 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ  
2020 ОН

## Агуулга

<b>1.ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ.....</b>	<b>2</b>
1.1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....	2
1.2.ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ .....	3
1.3.ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР, НӨӨЦ САН БА ЭЗДИЙН ӨМЧ .....	6
1.4.ДААТГАЛЫН ХУРААМЖ.....	8
1.5.ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР .....	10
1.6.ДААТГАГЧИЙН ХОХИРЛЫН ХАРЬЦАА .....	11
1.7.ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА.....	13
1.8.ДАВХАР ДААТГАЛ .....	14
<b>2.ЕРДИЙН ДААТГАЛ.....</b>	<b>14</b>
2.1.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ .....	14
2.2.ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР .....	16
2.3.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА.....	16
<b>3.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ.....</b>	<b>17</b>
<b>4. ДАВХАР ДААТГАЛ.....</b>	<b>18</b>
<b>5.АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ.....</b>	<b>19</b>
<b>6.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ.....</b>	<b>20</b>
6.1.ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ.....	20
6.2.ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ .....	22

## 1.ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

### 1.1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2019 оны жилийн эцсийн байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 2, даатгалын зуучлагч 54, даатгалын хохирол үнэлэгч 27 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Салбарын оролцогчдын тоон дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 1, 2-т харуулав.

Хүснэгт-1

#### Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

№		2018	2019
1	Ердийн даатгалын компани	15	15
2	Урт хугацааны даатгалын компани	1	1
3	Давхар даатгалын компани	2	2
4	Даатгалын төлөөлөгч	2430	2520
5	Даатгалын зуучлагч	49	54
6	Даатгалын хохирол үнэлэгч	27	27
7	Актуарч	28	30
8	Даатгалын үйл ажиллагаанд аудит хийх эрх бүхий аудитын компани	43	44
9	Даатгалын байгууллагад аудит хийх эрхтэй аудитор	141	144
	<b>НИЙТ</b>	<b>2736</b>	<b>2837</b>

Хүснэгт-2

#### Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогч компаниудын салбарын тоо

№		2018	2019
1	Даатгалын компанийн салбар	246	267
2	Даатгалын компанийн төлөөлөгчийн газар	12	14
3	Даатгалын зуучлагч компанийн салбар	22	22
4	Даатгалын зуучлагч банкны салбар	253	244
5	Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар	43	44
6	Даатгалын зуучлагч компанийн төлөөлөгчийн газар	0	2
7	Даатгалын хохирол үнэлэгч компанийн төлөөлөгчийн газар	18	37
	<b>НИЙТ</b>	<b>594</b>	<b>630</b>

2019 онд шинээр 7 компанид даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 2 компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт-3

#### 2019 онд даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон болон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон компаниуд

№	Компанийн нэр	Тусгай зөвшөөрөл олгосон огноо	Тогтоолын дугаар
1	"Амбрелла брокер" ХХК	2019.03.15	18
2	"Би Эйч Өү Кредит" ХХК	2019.04.24	61
3	"Цахим капитал" ХХК	2019.05.08	86
4	"Конкорал" ХХК	2019.06.14	132
5	"Тээвэр хөгжлийн банк" ХХК	2019.12.04	346
6	"Ги Ди Би Лизинг" ХХК	2019.12.16	373
7	"Богд банк" ХХК	2019.12.16	382
	<b>Компанийн нэр</b>	<b>Тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон огноо</b>	<b>Тогтоолын дугаар</b>
1	"Капитал банк" ХХК	2019.04.24	82
2	"Тэгш брокерс" ХХК	2019.08.14	230

2019 онд шинээр 2 компанид даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 2 компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт-4

**2019 онд даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон болон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон компаниуд**

№	Компанийн нэр	Тусгай зөвшөөрөл олгосон огноо	Тогтоолын дугаар
1	"Энхнахиа" ХХК	2019.08.28	237
2	"Итгэлт хөрөнгө" ХХК	2019.12.27	427
	Компанийн нэр	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон огноо	Тогтоолын дугаар
1	"Үнэлгээ консалтинг" ХХК	2019.03.11	16
2	"Арга билэг эстимэйт" ХХК	2019.08.28	249

Хорооны 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор "Гэр даатгал" ХХК-ийн оноосон нэрийг "Амар даатгал", 3 дугаар сарын 20-ны өдрийн 37 дугаар тогтоолоор "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК-ийн оноосон нэрийг "Үндэсний давхар даатгал", 10 дугаар сарын 16-ны өдрийн 287 дугаар тогтоолоор даатгалын зуучлагч "Бэст солюшн" ХХК-ийн оноосон нэрийг "Эн Ай Си Брокер" болгон тус тус өөрчлөх зөвшөөрөл олгосон.

Хорооны 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 372 дугаар тогтоолоор "Монгол даатгал" ХХК-ийг "Хорго хайрхан" ХК-д нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрч, "Хорго хайрхан" ХК-ийн оноосон нэрийг "Монгол даатгал" ХК болгон өөрчилсэнийг бүртгэсэн.

**1.2.ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ**

2013-2018 оны хооронд даатгалын компаниудын хөрөнгө жилд дунджаар 21 хувиар өсч ирсэн бөгөөд энэ хугацаанд 2 давхар даатгалын компани үүсгэн байгуулагдаж, даатгалын компаниудын дүрмийн сангийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх Хорооны 2012 оны 355 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдсан билээ.

Тайлант хугацаанд даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө 365.85 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.9 тэрбум төгрөгөөр буюу 10.2 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь зарим даатгалын компанийн үйл ажиллагаа өргөжиж, хуримтлагдсан ашиг, хураамжийн орлого түүнийг дагаад даатгалын нөөц сан нэмэгдсэнтэй холбоотой юм.

Дүрслэл-1



Даатгалын компаниудын нийт хөрөнгийн салбарын хэмжээнд эзлэх хувийг авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 76.85 хувь, давхар даатгалын компанийн хөрөнгө 20.62 хувь, урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө 2.53 хувийг тус тус эзэлж байна. Ердийн, урт хугацааны болон давхар даатгалын компаниудын хөрөнгө, салбарын нийт хөрөнгөд эзлэх хувийг Хүснэгт 5-т дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт-5

**Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө**

/сая төгрөгөөр/


№	Даатгалын компани	Нийт хөрөнгийн дүн		Өсөлт\ бууралт	Салбарт эзлэх хувь
		2018	2019		
<b>Ердийн даатгал</b>					
1	"Амар даатгал" ХХК	6,562	9,653	47%	2.6%
2	"Ард даатгал" ХК	21,003	20,824	-1%	5.7%
3	"Бодь даатгал" ХХК	29,475	27,557	-7%	7.5%
4	"Ганзам даатгал" ХХК	7,365	7,504	2%	2.1%
5	"Мандал даатгал" ХК	33,784	40,696	20%	11.1%
6	"Миг даатгал" ХХК	17,365	29,103	68%	8.0%
7	"Монгол даатгал" ХК	37,552	43,294	15%	11.8%
8	"Монре даатгал" ХХК	9,020	10,243	14%	2.8%
9	"Мөнх даатгал" ХХК	5,834	7,633	31%	2.1%
10	"Номин даатгал" ХХК	15,400	18,042	17%	4.9%
11	"Практикал даатгал" ХХК	16,190	17,735	10%	4.8%
12	"Соёмбо даатгал" ХХК	10,113	2,564	-75%	0.7%
13	"Тэнгэр даатгал" ХХК	23,561	27,425	16%	7.5%
14	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	7,079	7,337	4%	2.0%
15	"Хаан даатгал" ХХК	12,547	11,544	-8%	3.2%
<b>Нийт</b>		<b>252,851</b>	<b>281,153</b>	<b>11%</b>	<b>76.85%</b>
<b>Урт хугацааны даатгал</b>					
1	"Нэйшнл лайф даатгал" ХХК	8,878	9,249	4%	2.5%
<b>Нийт</b>		<b>8,878</b>	<b>9,249</b>	<b>4%</b>	<b>2.53%</b>
<b>Давхар даатгал</b>					
1	"Үндэсний давхар даатгал" ХК	48,610	53,329	10%	14.6%
2	"Хубилай давхар даатгал" ХХК	21,602	22,118	2%	6.0%
<b>Нийт</b>		<b>70,212</b>	<b>75,447</b>	<b>7%</b>	<b>20.62%</b>
<b>Компаниудын нийт хөрөнгө</b>		<b>331,941</b>	<b>365,849</b>	<b>10%</b>	<b>100.0%</b>

Тайлант хугацаанд даатгалын компаниудын мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, үндсэн ба биет бус хөрөнгийн цэвэр дүн тус бүр 19.7 болон 1.9 тэрбум төгрөгөөр буурч, хадгаламж, хадгаламжийн сертификат, үнэт цаас зэрэг хэлбэрээр байршуулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 26.2 тэрбум төгрөгөөр, даатгалын авлага, санхүүгийн бус хөрөнгө, даатгалын хөрөнгө зэрэг үлдэгдэл бусад хөрөнгийн дүн 29.3 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Салбарын хэмжээнд даатгалын компаниудын нийт хөрөнгийн бүтцийг авч үзвэл мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 9 хувийг, хөрөнгө оруулалт 57 хувийг, үндсэн ба биет бус хөрөнгө /цэвэр дүн/ 8 хувийг, бусад хөрөнгө 26 хувийг бүрдүүлж байна. Даатгалын компаниуд нийт хөрөнгийн дийлэнх буюу 54-71 хувийг хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулж байгаа боловч хөрөнгийн бүтэц ердийн, урт хугацааны болон давхар даатгалын компани эсэхээс хамааран харилцан адилгүй байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 6, Дүрслэл 2-д харуулав.

## Даатгагчийн хөрөнгийн бүтэц

/сая төгрөгөөр/

№	Компани	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		Хөрөнгө оруулалт		Үндсэн ба биет бус хөрөнгө /цэвэр/		Бусад хөрөнгө	
		2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
Ердийн даатгал									
1	"Амар даатгал" ХХК	619	522	5,528	6,633	28	116	387	2,382
2	"Ард даатгал" ХК	316	422	14,372	15,180	1,130	1,210	5,186	4,012
3	"Бодь даатгал" ХХК	3,839	750	7,224	9,262	2,072	1,990	16,341	15,555
4	"Ган зам даатгал" ХХК	86	80	6,848	7,011	93	64	338	349
5	"Мандал даатгал" ХК	3,082	3,305	19,837	25,237	385	607	10,480	11,547
6	"Миг даатгал" ХХК	1,663	367	10,400	10,177	2,148	2,313	3,154	16,247
7	"Монгол даатгал" ХК	1,525	1,561	12,587	11,314	9,765	9,535	13,675	20,883
8	"Монре даатгал" ХХК	2,356	2,863	4,247	3,155	915	1,523	1,502	2,702
9	"Мөнх даатгал" ХХК	472	424	4,166	5,206	1,061	1,080	135	923
10	"Номин даатгал" ХХК	12,159	624	-	14,923	1,708	1,665	1,533	831
11	"Практикал даатгал" ХХК	896	503	10,376	12,173	1,515	1,611	3,403	3,447
12	"Соёмбо даатгал" ХХК	32	9	6,278	3	2,383	104	1,420	2,448
13	"Тэнгэр даатгал" ХХК	2,408	1,500	15,331	19,431	1,272	1,329	4,550	5,166
14	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	149	1,686	4,187	2,929	2,082	2,126	661	596
15	"Хаан даатгал" ХХК	2,275	212	6,558	7,821	1,588	1,169	2,126	2,343
Нийт		31,877	14,829	127,940	150,453	28,144	26,441	64,889	89,430
Урт хугацааны даатгал									
1	"Нэйшнл лайф даатгал" ХХК	218	64	6,006	6,605	2,573	2,447	81	133
Нийт		218	64	6,006	6,605	2,573	2,447	81	133
Давхар даатгал									
1	"Үндэсний давхар даатгал" ХК	673	1,268	46,751	49,824	893	832	293	1,404
2	"Хубилай давхар даатгал" ХХК	21,535	18,481	-	-	62	44	4	3,593
Нийт		22,209	19,749	46,751	49,824	955	876	297	4,998
Нийт салбарын хэмжээнд		54,304	34,642	180,697	206,882	31,672	29,764	65,268	94,561



### 1.3.ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР, НӨӨЦ САН БА ЭЗДИЙН ӨМЧ

2019 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс даатгалын компаниудын өр төлбөр 7.4 тэрбум төгрөгөөр, нөөц сан 6.4 тэрбум төгрөгөөр, эздийн өмч 7 тэрбум төгрөгөөр, ердийн даатгалын компаниудын орлогод тооцоогүй хураамжийн нөөц 13.2 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Ердийн даатгалын компаниудын хувьд нийт өр төлбөр ба эздийн өмчийн 9 хувийг өр төлбөр, 31 хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц, 16 хувийг нөхөн төлбөрийн нөөц сан, 44 хувийг эздийн өмч бүрдүүлж байгаа бол урт хугацааны болон давхар даатгалын компаниудын хувьд өр төлбөр 0.3-3 хувь, нөөц сан 25-41 хувь, эздийн өмч 56-75 хувийг бүрдүүлж байна. Компаниудын өр төлбөр, нөөц сан ба эздийн өмчийг Хүснэгт 7, Дүрслэл 3-д дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт-7


#### Даатгалын компаниудын өр төлбөр, нөөц сан ба эздийн өмч

/сая төгрөгөөр/

№	Компани	Өр төлбөр		Орлогод тооцоогүй хураамжийн нөөц		Нөөц сан		Эздийн өмч	
		2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
Ердийн даатгал									
1	"Амар даатгал" ХХК	35	684	106	2,204	917	1,201	5,504	5,564
2	"Ард даатгал" ХК	1,814	1,139	6,178	4,875	2,292	3,005	10,719	11,805
3	"Бодь даатгал" ХХК	5,883	6,143	12,013	10,148	3,291	2,748	8,289	8,518
4	"Ган зам даатгал" ХХК	32	30	288	298	789	812	6,255	6,364
5	"Мандал даатгал" ХК	1,711	2,589	13,115	12,834	3,383	4,594	15,575	20,679

6	"Миг даатгал" ХХК	76	4,096	6,925	14,577	3,156	2,812	7,208	7,619
7	"Монгол даатгал" ХК	2,604	5,297	12,323	15,039	10,427	9,315	12,198	13,643
8	"Монре даатгал" ХХК	55	250	2,376	2,542	1,039	602	5,550	6,850
9	"Мөнх даатгал" ХХК	11	22	172	853	350	1,244	5,302	5,514
10	"Номин даатгал" ХХК	204	521	2,434	3,479	5,492	5,731	7,270	8,311
11	"Практикал даатгал" ХХК	659	380	5,136	6,271	3,608	2,540	6,788	8,544
12	"Соёмбо даатгал" ХХК	587	303	1,801	228	2,772	2,949	4,952	(917)
13	"Тэнгэр даатгал" ХХК	2,653	2,329	7,037	9,149	4,889	6,315	8,982	9,633
14	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	49	138	373	384	1,117	1,011	5,540	5,803
15	"Хаан даатгал" ХХК	1,925	234	2,975	3,578	1,328	1,226	6,318	6,507
Нийт		18,298	24,153	73,251	86,458	44,850	46,105	116,452	124,437
Урт хугацааны даатгал									
1	"Нэйшнл лайф даатгал" ХХК	18	27			2,037	2,320	6,823	6,902
Нийт		18	27			2,037	2,320	6,823	6,902
Давхар даатгал									
1	"Үндэсний давхар даатгал" ХК	542	1,917			20,907	25,754	27,161	25,657
2	"Хубилай давхар даатгал" ХХК	216	315			5,000	5,007	16,413	16,797
Нийт		758	2,232			25,907	30,761	43,574	42,454
Нийт салбарын хэмжээнд		19,074	26,412	73,251	86,458	72,794	79,186	166,849	173,793

Дүрслэл-3




#### 1.4.ДААТГАЛЫН ХУРААМЖ

Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2019 онд нийт 196.6 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажилласнаас 99.4 хувь буюу 195.3 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 0.6 хувь буюу 1.3 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани тус тус бүрдүүлсэн. Мөн нийт хураамжаас 7.1 тэрбум төгрөгийн хураамжийн буцаалт хийгдэж, 57.3 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжийн зардалд зарцуулснаар даатгалын цэвэр хураамжийн орлого 132.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Давхар даатгалын компаниуд 2.1 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамж төвлөрүүлж, үүнээс 1.7 тэрбум төгрөгийг гадны давхар даатгагчид давхар даатгалын хураамж /retrocession/ хэлбэрээр шилжүүлсэн байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 8-д харуулав.


Тайлант хугацааны ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.6 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд нийт хураамжийн сүүлийн 5 жилийн дундаж өсөлт 13.1 хувьтай байна.

Дүрслэл-4



2019 онд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт хураамжийн 29 хувь буюу 57.3 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжийн зардалд зарцуулсан байна. Үүнд нийт хураамжийн 69 хувийг бүрдүүлж буй “Бодь даатгал” ХХК, “Мандал даатгал” ХК, “Монгол даатгал” ХК, “Миг даатгал” ХХК болон “Тэнгэр даатгал” ХХК нийт хураамжийнхаа 30.7-46.6 хувийг давхар даатгалын хураамжийн зардалд зарцуулсан нь голлох нөлөөг үзүүлсэн юм. Сүүлийн 5 жилийн дунджаар давхар даатгалын хураамжийн нийт хураамжид эзлэх хувь 32.4 хувь байна.

Дүрслэл-5



Ердийн болон урт хугацааны даатгалын хураамжийн 22 хувь буюу 44.6 тэрбум төгрөгийн хураамжийг даатгалын төлөөлөгч, 12 хувь буюу 23.2 тэрбум төгрөгийн хураамжийг даатгалын зуучлагч банк, 10 хувь буюу 19.3 тэрбум төгрөгийн хураамжийг даатгалын зуучлагч компани тус тус бүрдүүлсэн байна.

## Даатгалын компаниудын нийт хураамж, цэвэр хураамж

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компани	Нийт хураамж				Даатгалын хураамжийн буцаалт	Давхар даатгалын хураамжийн зардал	Даатгалын хураамжийн цэвэр орлого
		2018	2019	Өсөлт\ бууралт	Салбарт эзлэх хувь			
<b>Ердийн даатгал</b>								
1	"Амар даатгал" ХХК	621	5,339	760%	2.7%	326	2,687	2,325
2	"Ард даатгал" ХК	13,001	11,409	-12%	5.8%	431	2,082	8,896
3	"Бодь даатгал" ХХК	35,488	27,946	-21%	14.2%	893	13,021	14,032
4	"Ганзам даатгал" ХХК	609	684	12%	0.3%	0	-	684
5	"Мандал даатгал" ХК	27,786	28,927	4%	14.7%	2,211	10,842	15,874
6	"Миг даатгал" ХХК	16,645	26,850	61%	13.7%	639	8,236	17,976
7	"Монгол даатгал" ХК	30,408	32,659	7%	16.6%	654	10,468	21,536
8	"Монре даатгал" ХХК	5,083	6,538	29%	3.3%	466	237	5,835
9	"Мөнх даатгал" ХХК	1,154	3,007	161%	1.5%	22	21	2,964
10	"Номин даатгал" ХХК	6,447	8,382	30%	4.3%	255	256	7,871
11	"Практикал даатгал" ХХК	10,946	12,504	14%	6.4%	310	1,528	10,666
12	"Соёмбо даатгал" ХХК	3,964	1,725	-56%	0.9%	173	554	997
13	"Тэнгэр даатгал" ХХК	14,523	19,184	32%	9.8%	414	6,970	11,799
14	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	1,197	1,231	3%	0.6%	1	-	1,230
15	"Хаан даатгал" ХХК	7,673	8,944	17%	4.5%	357	394	8,194
<b>Нийт</b>		<b>175,546</b>	<b>195,328</b>	<b>11%</b>	<b>99.4%</b>	<b>7,152</b>	<b>57,297</b>	<b>130,879</b>
<b>Урт хугацааны даатгал</b>								
1	"Нэйшнл лайф даатгал" ХХК	1,421	1,272	-10%	0.6%	4	25	1,243
<b>Нийт</b>		<b>1,421</b>	<b>1,272</b>	<b>-10%</b>	<b>0.6%</b>	<b>4</b>	<b>25</b>	<b>1,243</b>
<b>Нийт ердийн болон урт хугацааны даатгал</b>		<b>176,966</b>	<b>196,600</b>	<b>11%</b>	<b>100.0%</b>	<b>7,156</b>	<b>57,323</b>	<b>132,122</b>
<b>Давхар даатгал</b>								
1	"Үндэсний давхар даатгал" ХК	1,738	2,075	19%		-	1,708	367
2	"Хубилай давхар даатгал" ХХК	-	30	-		-	-	30
<b>Нийт</b>		<b>1,738</b>	<b>2,105</b>	<b>21%</b>		<b>-</b>	<b>1,708</b>	<b>397</b>

## 1.5.ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Даатгалын тохиолдлын улмаас урт хугацааны болон ердийн даатгалын компаниуд 2019 онд нийт 65.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. “Монгол даатгал” ХК 17.9 тэрбум төгрөгийн, “Бодь даатгал” ХХК 8.0 тэрбум төгрөгийн, “Миг даатгал” ХХК 7.4 тэрбум төгрөгийн, “Мандал даатгал” ХК, “Практикал даатгал” ХХК тус бүр 5.4 тэрбум төгрөгийн, “Тэнгэр даатгал” ХХК 5.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь нийт нөхөн төлбөрийн 78.4 хувийг эзэлж байна. Нийт салбарын хэмжээнд авч үзвэл нөхөн төлбөрийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт-9

### Даатгалын компаниудын нөхөн төлбөр, цэвэр нөхөн төлбөрийн зардал


/сая төгрөгөөр/

№	Даатгалын компани	Нийт нөхөн төлбөр		Өсөлт\ бууралт	Салбарт эзлэх хувь	Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	Нөхөн төлбөрийн цэвэр зардал
		2018	2019					
<b>Ердийн даатгал</b>								
1	"Амар даатгал" ХХК	308	397	29%	0.6%	3	1	393
2	"Ард даатгал" ХК	6,012	4,423	-26%	6.8%	451	12	3,961
3	"Бодь даатгал" ХХК	6,234	7,971	28%	12.2%	2,045	410	5,515
4	"Ганзам даатгал" ХХК	67	85	27%	0.1%	-	-	85
5	"Мандал даатгал" ХК	4,324	5,423	25%	8.3%	674	384	4,364
6	"Миг даатгал" ХХК	13,043	7,362	-44%	11.2%	-	349	7,013
7	"Монгол даатгал" ХК	8,579	17,868	108%	27.3%	7,840	129	9,898
8	"Монре даатгал" ХХК	2,538	3,166	25%	4.8%	-	-	3,166
9	"Мөнх даатгал" ХХК	152	353	132%	0.5%	-	-	353
10	"Номин даатгал" ХХК	2,107	2,649	26%	4.0%	-	-	2,649
11	"Практикал даатгал" ХХК	3,903	5,348	37%	8.2%	149	332	4,867
12	"Соёмбо даатгал" ХХК	1,752	1,046	-40%	1.6%	339	37	670
13	"Тэнгэр даатгал" ХХК	4,928	4,977	1%	7.6%	288	31	4,659
14	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	496	237	-52%	0.4%	-	-	237
15	"Хаан даатгал" ХХК	2,689	3,656	36%	5.6%	5	3	3,648
<b>Нийт</b>		<b>57,131</b>	<b>64,961</b>	<b>14%</b>	<b>99.2%</b>	<b>11,795</b>	<b>1,689</b>	<b>51,477</b>
<b>Урт хугацааны даатгал</b>								
1	"Нэйшнл лайф даатгал" ХХК	559	512	-9%	0.8%	-	-	512
<b>Нийт</b>		<b>559</b>	<b>512</b>	<b>-9%</b>	<b>0.8%</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>512</b>
<b>Нийт ердийн болон урт хугацааны даатгал</b>		<b>57,691</b>	<b>65,473</b>	<b>13%</b>	<b>100.0%</b>	<b>11,795</b>	<b>1,689</b>	<b>51,989</b>

“Үндэсний давхар даатгал” ХК нь 2018 онд 522 сая төгрөгийн, 2019 онд 18 сая төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон байна. Харин тайлант хугацаанд “Хубилай давхар даатгал” ХХК нөхөн төлбөр олгоогүй байна.

Тайлант хугацаанд ердийн болон урт хугацааны даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн 20.4 хувийг давхар даатгагч хариуцсан байх бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг сүүлийн 5 жилийн байдлаар Дүрслэл 6-д харуулав.

Дүрслэл-6



### 1.6.ДААТГАГЧИЙН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Тайлант хугацаанд нийт хохирлын харьцаа ердийн даатгалын компаниудын хувьд 36.0 хувь, урт хугацааны даатгалын компанийн хувьд 40.3 хувь, давхар даатгалын компаниудын хувьд 0.9 хувь байна. Үүнд давхар даатгалд төлсөн хураамж болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оруулж тооцсон болно. Дэлгэрэнгүйг Хүснэгт-10-д харуулав.

Хүснэгт-10

#### Даатгалын компаниудын нийт хохирлын харьцаа

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компани	Давхар даатгалын хураамжийн зардал	Орлогод тооцсон хураамж	Нийт нөхөн төлбөрийн зардал	Хохирлын харьцаа <4> = (<3> / (<1> + <2>))
А	Б	<1>	<2>	<3>	<4>
<b>Ердийн даатгал</b>					
1	"Амар даатгал" ХХК	2,687	1,106	397	10.5%
2	"Ард даатгал" ХК	2,082	9,624	4,423	37.8%
3	"Бодь даатгал" ХХК	13,021	12,456	7,971	31.3%
4	"Ганзам даатгал" ХХК	0	673	85	12.6%
5	"Мандал даатгал" ХК	10,842	16,422	5,423	19.9%
6	"Миг даатгал" ХХК	8,236	14,450	7,362	32.5%
7	"Монгол даатгал" ХК	10,468	21,295	17,868	56.3%
8	"Монре даатгал" ХХК	237	5,724	3,166	53.1%
9	"Мөнх даатгал" ХХК	21	2,284	353	15.3%
10	"Номин даатгал" ХХК	256	6,790	2,649	37.6%
11	"Практикал даатгал" ХХК	1,528	10,594	5,348	44.1%

12	"Соёмбо даатгал" ХХК	554	2,506	1,046	34.2%
13	"Тэнгэр даатгал" ХХК	6,970	10,226	4,977	28.9%
14	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	0	1,219	237	19.4%
15	"Хаан даатгал" ХХК	394	7,662	3,656	45.4%
Нийт		57,297	123,030	64,961	36.0%
<b>Урт хугацааны даатгал</b>					
	Даатгалын компани	Давхар даатгалын хураамж	Даатгалын цэвэр хураамжийн орлого	Нийт төлсөн нэхэмжлэл	Хохирлын харьцаа <4> = (<3> / (<1> + <2>)
1	"Нэйшнл лайф даатгал" ХХК	25	1,243	512	40.3%
Нийт		25	1,243	512	40.3%
<b>Давхар даатгал</b>					
1	"Үндэсний давхар даатгал" ХК	1,708	367	18	0.9%
2	"Хубилай давхар даатгал" ХХК	0	30	0	0.0%
Нийт		1,708	397	18	0.9%
Нийт даатгалын болон давхар даатгалын компаниуд		59,031	124,670	65,491	35.7%

Ердийн даатгалын компаниудын хохирлын харьцааг зардалд тооцсон нөхөн төлбөр (нөхөн төлбөрийн цэвэр зардал дээр нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлтүүдийг нэмсэн дүн) болон орлогод тооцсон хураамжийн харьцаагаар тооцоход 45.1 хувь байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 11-т харуулав.

Хүснэгт-11

**Ердийн даатгагчдын хохирлын харьцаа (цэвэр)**

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компани	Орлогод тооцсон хураамж	Зардалд тооцсон нөхөн төлбөр	Хохирлын харьцаа (цэвэр)
1	"Амар даатгал" ХХК	1,106	678	61.3%
2	"Ард даатгал" ХК	9,624	4,548	47.3%
3	"Бодь даатгал" ХХК	12,456	4,823	38.7%
4	"Ганзам даатгал" ХХК	673	107	16.0%
5	"Мандал даатгал" ХК	16,422	5,990	36.5%
6	"Миг даатгал" ХХК	14,450	6,569	45.5%
7	"Монгол даатгал" ХК	21,295	10,815	50.8%
8	"Монре даатгал" ХХК	5,724	2,728	47.7%
9	"Мөнх даатгал" ХХК	2,284	1,247	54.6%
10	"Номин даатгал" ХХК	6,790	2,887	42.5%
11	"Практикал даатгал" ХХК	10,594	4,381	41.4%
12	"Соёмбо даатгал" ХХК	2,506	982	39.2%
13	"Тэнгэр даатгал" ХХК	10,226	6,070	59.4%
14	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	1,219	131	10.8%
15	"Хаан даатгал" ХХК	7,662	3,559	46.4%
Нийт		123,030	55,515	45.1%

## 1.7.ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

Даатгалын компаниудын цэвэр ашиг 2019 онд 22.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 4.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт-12-т харуулав.

Хүснэгт-12


### Даатгалын компаниудын ашигт ажиллагаа

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компани	Тайлант үеийн цэвэр ашиг		Өсөлт\ бууралт
		2018	2019	
<b>Ердийн даатгал</b>				
1	"Амар даатгал" ХХК	495	59	-88%
2	"Ард даатгал" ХК	1,263	1,719	36%
3	"Бодь даатгал" ХХК	2,181	1,700	-22%
4	"Ганзам даатгал" ХХК	1,056	1,029	-3%
5	"Мандал даатгал" ХК	3,868	5,820	50%
6	"Миг даатгал" ХХК	133	410	207%
7	"Монгол даатгал" ХК	95	105	12%
8	"Монре даатгал" ХХК	110	1,370	1148%
9	"Мөнх даатгал" ХХК	294	212	-28%
10	"Номин даатгал" ХХК	1,007	1,042	3%
11	"Практикал даатгал" ХХК	1,244	2,037	64%
12	"Соёмбо даатгал" ХХК	342	685	100%
13	"Тэнгэр даатгал" ХХК	1,892	651	-66%
14	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	245	262	7%
15	"Хаан даатгал" ХХК	65	250	285%
Нийт		14,289	17,352	21%
<b>Урт хугацааны даатгал</b>				
1	"Нэйшнл лайф даатгал" ХХК	93	117	26%
Нийт		93	117	26%
<b>Давхар даатгал</b>				
1	"Үндэсний давхар даатгал" ХК	4,057	3,496	-14%
2	"Хубилай давхар даатгал" ХХК	-	1,747	-
Нийт		4,057	5,243	29%
<b>Нийт тайлант үеийн ашиг</b>		<b>18,439</b>	<b>22,712</b>	<b>23%</b>

Тайлант хугацаанд даатгалын компаниудын хуримтлагдсан ашиг 35.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.8 хувиар өссөн байна.


Дүрслэл-7



## 1.8. ДАВХАР ДААТГАЛ

2019 онд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 57.3 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн зардал гаргасан бөгөөд үүний 3.7 хувь буюу 2.1 тэрбум төгрөгийг дотоод давхар даатгагчдад даатгуулахад зарцуулсан байна. Сүүлийн 5 жилийн байдлаар ердийн болон урт хугацааны даатгалын компаниудын төлсөн давхар даатгалын хураамж, давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөр, тэдгээрийн харьцааг Дүрслэл 8-д харуулав.

Дүрслэл-8



## 2. ЕРДИЙН ДААТГАЛ

2019 онд 15 ердийн даатгалын компани, тэдгээрийн 266 салбар, 14 төлөөлөгчийн газар Улаанбаатар хот, орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

### 2.1. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд 15 сайн дурын болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хэлбэрээр нийт 168,604 даатгалын гэрээ байгуулж, 195.3 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлж, үүнээс давхар даатгалын хураамжид 57.3 тэрбум төгрөг төлж, 7.1 тэрбум төгрөгийн хураамжийн буцаалт хийж 130.9 тэрбум төгрөгийн хураамжийн цэвэр орлого тайлагнасан байна. Даатгалын компаниудын даатгалын хураамжийн талаар 1.4 дэх хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Ердийн даатгалын хураамжийн нийт орлогыг даатгалын хэлбэрээр ангилж, Хүснэгт 13-т харуулав.

Хүснэгт-13

Ердийн даатгалын хураамж

№	Даатгалын хэлбэр	Байгуулагдсан даатгалын гэрээний тоо		Даатгалын хураамж /сая төгрөгөөр/			
		2018	2019	2018	2019	Өсөлт\ бууралт	Эзлэх хувь
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	450,016	168,604	25,252	32,313	28%	16.5%

2	Хөрөнгийн даатгал	116,521	138,526	41,925	43,343	3%	22.2%
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	84,749	78,785	28,132	34,718	23%	17.8%
4	Ачааны даатгал	1,106	992	3,444	3,686	7%	1.9%
5	Барилга угсралтын даатгал	47	61	8,039	7,755	-4%	4.0%
6	Газар тариалангийн даатгал	15	7	136	33	-76%	0.0%
7	Мал амьтдын даатгал	3,072	1,874	3,466	3,884	12%	2.0%
8	Агаарын хөлгийн даатгал	25	38	1,277	7,139	459%	3.7%
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	304	364	535	628	17%	0.3%
10	Хариуцлагын даатгал	39,022	77,821	14,999	13,796	-8%	7.1%
11	Санхүүгийн даатгал	33,069	277	3,489	1,179	-66%	0.6%
12	Зээлийн даатгал	63,883	33,384	3,293	2,745	-17%	1.4%
13	Итгэлцлийн даатгал	35	18	385	305	-21%	0.2%
14	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	1	1	51	50	-2%	0.0%
15	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	35	38	8,141	7,270	-11%	3.7%
16	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	688,511	652,078	32,980	36,486	11%	18.7%
Нийт		1,480,411	1,152,868	175,546	195,328	11%	100.0%

Тайлант хугацааны даатгалын нийт хураамжийн орлогын 75.2 хувь нь даатгалын 4 хэлбэрийн хураамжийн орлогоос бүрдэж байна. Нийт хураамжийн орлогын бүтцээс үзэхэд 22.2 хувийг хөрөнгийн даатгал, 18.7 хувийг ЖХАЖД, 17.8 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 16.5 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгалын хураамж тус тус эзэлж байна.

Дүрслэл-9



## 2.2.ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 65.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчид олгосноос 11.8 тэрбум төгрөгийг давхар даатгагч, 1.7 тэрбум төгрөгийг буруутай этгээд, 51.5 тэрбум төгрөгийг даатгагч нар тус тус төлсөн байна. Даатгалын компаниудын даатгалын нөхөн төлбөрийн талаар 1.5 дах хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Ердийн даатгалын компаниудын олгосон даатгалын нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр ангилж, Хүснэгт 14-т харуулав.

Хүснэгт-14

### Ердийн даатгалын нөхөн төлбөр

№	Даатгалын хэлбэр	Нөхөн төлбөр олгогдсон даатгалын гэрээний тоо		Даатгалын нөхөн төлбөр /сая төгрөгөөр/			
		2018	2019	2018	2019	Өсөлт\бууралт	Эзлэх хувь
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	12,706	5,546	7,547	9,518	26%	14.7%
2	Хөрөнгийн даатгал	2,643	2,365	2,698	11,636	331%	17.9%
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	15,231	12,862	13,153	17,548	33%	27.0%
4	Ачааны даатгал	102	56	216	652	202%	1.0%
5	Барилга угсралтын даатгал	4	9	8,469	128	-98%	0.2%
6	Газар тариалангийн даатгал	0	6	420		-100%	0.0%
7	Мал амьтдын даатгал	32	759	1,286	440	-66%	0.7%
8	Агаарын хөлгийн даатгал	7	0	7	1,179	16815%	1.8%
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	40	32	59	43	-27%	0.1%
10	Хариуцлагын даатгал	877	578	2,983	1,369	-54%	2.1%
11	Санхүүгийн даатгал	13	1,564	1,294	515	-60%	0.8%
12	Зээлийн даатгал	165	270	1,461	2,742	88%	4.2%
13	Итгэлцлийн даатгал	0	1	15		-100%	0.0%
14	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	0	0			-	0.0%
15	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	4	1	463	19	-96%	0.0%
16	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	23,719	23,145	17,062	19,173	12%	29.5%
Нийт		55,543	47,194	57,131	64,961	14%	100.0%

Тайлант хугацааны даатгалын нийт нөхөн төлбөрийн 89.1 хувь нь даатгалын 4 хэлбэрийн нөхөн төлбөрөөс бүрдэж байна. Үүнд 17.9 хувийг хөрөнгийн даатгал, 29.5 хувийг ЖХАЖД, 27 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 14.7 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгалын нөхөн төлбөр тус тус эзэлж байна.

## 2.3.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

2019 онд ердийн даатгалын цэвэр хохирлын харьцаа 45 хувь байгаа бөгөөд барилга угсралт, зээл, автотээврийн хэрэгсэл, ачааны даатгал, ЖХАЖД, агаарын хөлгийн даатгалын хохирлын харьцаа харьцангуй өндөр дүнтэй байна. Хохирлын харьцааг тооцоход тус тайлангийн 1.6-д дурдсан ердийн даатгагчийн хохирлын харьцааг тооцох аргыг ашигласан болно. Хүснэгт 15-д нэр бүхий 12 даатгалын хэлбэрийн хохирлын харьцааг харуулав.

## Ердийн даатгалын хохирлын харьцаа

/сая төгрөгөөр/

№	Даатгалын хэлбэр	Орлогод тооцсон хураамжийн дүн	Зардалд тооцсон нөхөн төлбөрийн дүн	Хохирлын харьцаа
А		<1>	<2>	<4> = <2> / <1>
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	23,560	8,703	37%
2	Хөрөнгийн даатгал	19,402	4,124	21%
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	28,955	17,666	61%
4	Ачааны даатгал	1,506	863	57%
5	Барилга угсралтын даатгал	398	1,477	371%
6	Мал амьтдын даатгал	2,686	137	5%
7	Агаарын хөлгийн даатгал	186	109	59%
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	596	102	17%
9	Хариуцлагын даатгал	7,744	764	10%
10	Санхүүгийн даатгал	883	117	13%
11	Зээлийн даатгал	3,407	2,976	87%
12	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	33,162	18,699	56%
Нийт		123,030	55,515	45%

**3.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ**

Тайлант хугацаанд “Нэйшнл лайф даатгал” ХХК 5 урт хугацааны даатгалын хэлбэрийн хүрээнд 578 даатгалын гэрээ байгуулж, 1.3 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлсэн ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 хувиар буурсан үзүүлэлт юм. Мөн нийт нөхөн төлбөрийн хэмжээ 9 хувиар буурч, 512.0 сая төгрөгт хүрсэн байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 16, 17-д харуулав.

Хүснэгт-16

**Урт хугацааны даатгалын хураамж**

№	Даатгалын хэлбэр	Байгуулагдсан даатгалын гэрээний тоо		Даатгалын нийт хураамж /сая төгрөгөөр/			
		2018	2019	2018	2019	Өсөлт\ бууралт	Эзлэх хувь
1	Хугацаат амьдралын даатгал	1305	126	159	175	10%	13.7%
2	Насан туршийн даатгал	0	2	-	2	-	0.1%
3	Хуримтлалын даатгал	96	91	205	99	-52%	7.8%
4	Тэтгэврийн даатгал	75	166	41	204	401%	16.0%
5	Эрүүл мэндийн даатгал	24	193	1,016	793	-22%	62.3%
Нийт		1500	578	1,421	1,272	-10%	100.0%

Хүснэгт-17


**Урт хугацааны даатгалын нөхөн төлбөр**

№	Даатгалын хэлбэр	Нөхөн төлбөр олгогдсон даатгалын гэрээний тоо		Нийт нөхөн төлбөр /сая төгрөгөөр/			
		2018	2019	2018	2019	Өсөлт\ бууралт	Эзлэх хувь
1	Хугацаат амьдралын даатгал	42	48	81	30	-63%	5.8%

2	Насан туршийн даатгал	0	0	-	-	-	-
3	Хуримтлалын даатгал	13	30	111	84	-25%	16.4%
4	Тэтгэврийн даатгал	1	20	14	38	176%	7.4%
5	Эрүүл мэндийн даатгал	44	63	354	360	2%	70.3%
Нийт		100	161	559	512	-9%	100.0%

Урт хугацааны даатгагчийн хураамжийн нийт орлого, нийт нөхөн төлбөрийн харьцаа 40.2 хувьтай байна. Сүүлийн 5 жилийн урт хугацааны даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, тэдгээрийн харьцааг Дүрслэл-10-д харуулав.

Дүрслэл-10



#### 4. ДАВХАР ДААТГАЛ

Тайлант хугацаанд “Үндэсний давхар даатгал” ХК, “Хубилай давхар даатгал” ХХК нийт 11 даатгалын хэлбэрийн 45 давхар даатгалын гэрээ байгуулж, нийт 2.1 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласан байна. Дотоодын давхар даатгагчдын хураамжийн бүтцийг авч үзвэл 76.6 хувийг мал амьтдын даатгал, 13.6 хувийг хөрөнгийн даатгал, үлдсэн 9.8 хувийг бусад даатгалын хэлбэрийн хураамжийн орлого бүрдүүлж байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 18-д харуулав.

Хүснэгт-18

#### Дотоодын давхар даатгагчийн даатгалын хураамж, нөхөн төлбөр

/сая төгрөгөөр/

№	Даатгалын хэлбэр	Даатгалын гэрээний тоо		Даатгалын нийт хураамж		Нийт төлсөн нэхэмжлэл	
		2018	2019	2018	2019	2018	2019
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал		4		1.7		-
2	Хөрөнгийн даатгал	2	9	29.8	286.6		-
3	Автотээврийн хэрэгслийн даатгал		1		1.1		-

4	Ачааны даатгал		3		14.7		-
5	Барилга угсралтын даатгал		2		14.2		-
6	Газар тариалангийн даатгал	1	2	115.7	29.6	502.0	-
7	Мал амьтдын даатгал	10	10	1,592.8	1,613.3	19.9	18.5
8	Агаарын хөлгийн даатгал		3		22.2		-
9	Хариуцлагын даатгал		6		74.5		-
10	Санхүүгийн даатгал		1		1.2		-
11	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал		4		46.3		-
Нийт		13	45	1,738.3	2,105.2	521.9	18.5

### **5.АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ**

2019 онд ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид “жолоочийн хариуцлагын даатгал” гэх/-ын үйл ажиллагаа эрхэлж 36.5 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 3.5 тэрбум төгрөгөөр буюу 10.6%-иар өссөн байна. Нийт хураамжийн 47.6 хувийг 3 даатгалын компани бүрдүүлж байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 19-д харуулав.

Хүснэгт -19

#### **Жолоочийн хариуцлагын даатгалын хураамж**

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компани	Нийт хураамж		Өсөлт/ бууралт	Эзлэх хувь
		2018	2019		
1	"Амар даатгал" ХХК	177	341	92.7%	0.9%
2	"Ард даатгал" ХК	2,445	2,669	9.1%	7.3%
3	"Бодь даатгал" ХХК	4,207	4,799	14.1%	13.2%
4	"Ганзам даатгал" ХХК	34	50	46.8%	0.1%
5	"Мандал даатгал" ХК	545	490	-10.0%	1.3%
6	"Миг даатгал" ХХК	5,156	5,574	8.1%	15.3%
7	"Монгол даатгал" ХК	6,340	6,991	10.3%	19.2%
8	"Монре даатгал" ХХК	2,590	3,107	20.0%	8.5%
9	"Мөнх даатгал" ХХК	625	588	-6.0%	1.6%
10	"Номин даатгал" ХХК	2,144	2,637	23.0%	7.2%
11	"Практикал даатгал" ХХК	2,473	2,352	-4.9%	6.4%
12	"Соёмбо даатгал" ХХК	1,365	542	-60.3%	1.5%
13	"Тэнгэр даатгал" ХХК	2,241	3,453	54.1%	9.5%
14	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	9	14	62.3%	0.0%
15	"Хаан даатгал" ХХК	2,630	2,880	9.5%	7.9%
Нийт		32,980	36,486	10.6%	100.0%

Тайлант хугацаанд даатгалын компаниуд жолоочийн хариуцлагын даатгалаар нийт 19.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгож, өмнөх оны мөн үеэс 12.4 хувиар өссөн байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 20-т харуулав.

## Жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөр

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компани	Нийт нөхөн төлбөр		Өсөлт/ бууралт	Эзлэх хувь
		2018	2019		
1	"Амар даатгал" ХХК	250	101	-59.7%	0.5%
2	"Ард даатгал" ХК	1,073	1,286	19.9%	6.7%
3	"Бодь даатгал" ХХК	2,107	2,646	25.6%	13.8%
4	"Ганзам даатгал" ХХК	12	19	59.9%	0.1%
5	"Мандал даатгал" ХК	505	275	-45.6%	1.4%
6	"Миг даатгал" ХХК	2,913	2,996	2.8%	15.6%
7	"Монгол даатгал" ХК	3,075	3,628	18.0%	18.9%
8	"Монре даатгал" ХХК	1,687	1,729	2.5%	9.0%
9	"Мөнх даатгал" ХХК	51	79	52.7%	0.4%
10	"Номин даатгал" ХХК	1,110	1,376	24.0%	7.2%
11	"Практикал даатгал" ХХК	1,112	1,214	9.2%	6.3%
12	"Соёмбо даатгал" ХХК	668	397	-40.6%	2.1%
13	"Тэнгэр даатгал" ХХК	1,039	1,514	45.6%	7.9%
14	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	2	2	19.4%	0.0%
15	"Хаан даатгал" ХХК	1,458	1,912	31.1%	10.0%
Нийт		17,062	19,173	12.4%	100.0%

**6.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ**

## 6.1.ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант хугацаанд 43 даатгалын зуучлагч компани, 11 банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж ердийн даатгалын 12, урт хугацааны даатгалын 2 хэлбэрээр нийт 54.5 тэрбум төгрөгийн даатгалын болон давхар даатгалын хураамж зуучилсан байна.

Хүснэгт-21

**Даатгалын зуучлагчийн зуучилсан даатгалын хураамж, шимтгэлийн орлого**


/сая төгрөгөөр/

№	Даатгалын зуучлагч компани	Зуучилсан даатгалын болон давхар даатгалын хураамжийн орлого	Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого
Давхар даатгалын зуучлагч компани			
1	Ай Ай Би	250.4	28.7
2	Асимон брокерс	1,382.9	200.2
3	Ачит ундарга	1,048.8	158.8
4	Ковер хилл	1,344.8	174.2
5	КОНКОРАЛ	4.1	0.6
6	Монголиан интернэшнл брокерс	2,195.1	23.7
7	Си эн эн икс	4,074.0	601.4
8	Хост рок	2,154.0	341.9
9	Хүннү сизл	0.4	0.1
Даатгалын зуучлагч компани			
10	Амбрелла брокер	1.4	0.3
11	АМЕ	630.3	91.3
12	Ар Эм Ай Би	#N/A	#N/A
13	Арм интернэшнл	0.4	0.1

14	Би эйч өү кредит	9.8	2.0
15	Ваяснью Солюшн	836.2	198.0
16	Дэвжих дэлгэрэх холдинг	586.3	138.8
17	Ивээлт-Очир	1,492.3	276.5
18	Лоялти солюшн	1,148.3	214.1
19	Марш брокерс	0.3	0.1
20	Мастер шийдэл	4.7	1.1
21	Монгол бичээч зууч	601.4	166.0
22	Монголиан иншуранс Брокерейж	80.1	23.9
23	Нэйшнл эженси	1,688.3	182.6
24	Онолт язгуур	0.2	0.0
25	Ренессанс групп	141.0	29.9
26	Смарт брокерс	2,135.9	591.0
27	Соёмбо брокер	5.6	1.1
28	Сүрэг хараацай	1,986.2	468.9
29	Ти Ди Би Лизинг	0.0	0.0
30	Тод капитал	1,024.5	219.2
31	Тус брокерс	47.5	17.2
32	Түвшин Оргил	1,857.7	312.8
33	Цагаан гэрэлт	157.6	32.1
34	Цахим капитал	4.2	0.7
35	Чанд финтех	32.0	6.4
36	Эл Би брокерэж	569.6	108.0
37	Эм жи ай би	609.3	125.4
38	Эм эн ай би	130.1	25.6
39	Эн Ай Си Брокер	16.1	16.1
40	Эн И Би Консалтэнси	0.0	0.0
41	Эрсдэлийн шийдэл	1,773.8	447.8
42	Эс ай би эс	16.9	5.1
43	Эс Ти Ди	1,252.4	438.4
Даатгалын зуучлагч-банк			
44	Ариг банк	54.0	9.2
45	Богд банк	0.0	0.0
46	Голомт банк	4,279.8	686.2
47	Капитрон банк	251.7	55.4
48	Төрийн банк	4,396.5	994.2
49	Тээвэр хөгжлийн банк	0.0	0.0
50	Улаанбаатар хотын банк	519.6	77.9
51	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	1,572.4	350.8
52	Хаан банк	4,843.7	1,129.8
53	ХасБанк	2,000.9	483.8
54	Худалдаа хөгжлийн банк	5,251.0	1,005.7
Нийт		54,537.9	10,462.8

*Тэмдэглэл: (-)-үйл ажиллагаа эрхлээгүй, (#N/A)-Фина системд тайлан ирүүлээгүй*

2019 онд даатгалын зуучлагч компаниуд 5.7 тэрбум төгрөгийн, даатгалын зуучлагч банкууд 4.8 тэрбум төгрөгийн даатгалын зуучлалын шимтгэлийн орлоготой ажиллаж, нийт даатгалын зуучлалын шимтгэлийн орлого 10.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар өссөн байна.



\* Зуучилсан давхар даатгалын хураамжийн орлого багтсан болно.

## 6.2.ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Тайлант хугацаанд 23 даатгалын хохирол үнэлэгч компани тайлан ирүүлсэн ба тус компаниуд нийт 6 даатгалын хэлбэрийн 26,402 хохирлыг үнэлж, 1.1 тэрбум төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ. Нийт дүнгээрээ даатгалын хохирол үнэлгээний орлого нь өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өссөн байна.

Хүснэгт-22

### Даатгалын хохирол үнэлгээний орлого

/сая төгрөгөөр/

№	Даатгалын хохирол үнэлэгч компани	Даатгалын хохирлыг үнэлсэн тоо	Даатгалын хохирол үнэлгээний орлого
1	Арвижих эстимэйт	692	30.0
2	Ашид билгүүн	8,034	367.2
3	Банхас	1,317	23.0
4	Бэст эстимэйт	46	65.2
5	Вендо	1,825	110.2
6	Виннэрвэй	583	25.5
7	Голд стандарт эстимейт	#N/A	#N/A
8	Гэрэгэ эстимэйт	2,169	55.9
9	Далайван аудит	0	0.0
10	Итгэлт эстимэйт	134	13.2
11	Кости эстимэйт	2,125	47.4
12	Мастер Үнэлгээ	1,401	101.2
13	Мөнх эстимэйт	11	0.9
14	Сүлд үнэлгээ	874	32.2
15	Сэлэнгэ эстимэйт	#N/A	#N/A
16	Тод үнэлгээ	94	6.5
17	Тэнцвэр эстимэйт	1,546	56.3
18	Ухаашүрт консалтинг	1,207	42.4
19	Файн эстимэйт	5	0.2
20	Фэйр валуэшн	429	15.6
21	Хан-Үнэлэмж	980	3.7
22	Хас үнэлгээ	1,468	48.3

23	Хос стандарт	245	7.7
24	Хөрөнгө үнэлгээний төв	34	1.0
25	Хөрөнгө эстимэйт	1,148	41.3
Нийт		26,402	1,096.8

*Тэмдэглэл:(-)-үйл ажиллагаа эрхлээгүй,(#N/A)-Фина системд тайлан ирүүлээгүй*

-ДААТГАЛЫН ГАЗАР-